

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 16

Дугаар 43

Улаанбаатар хот

“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер”
төсөл батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийг хавсралтаар баталсугай.

2.Тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч ажиллахыг дүүргийн Засаг дарга (Г.Жаргалсайхан)-д даалгасугай.

2.1.“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийг дүүргийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, нийслэл, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2.2.“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг хангахад бүх талын арга хэмжээг авч ажиллах;

2.3.“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (А.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.МЭНДСАЙХАН



“МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

АГУУЛГА:

- Удиртгал
- Хууль, эрх зүйн үндэслэл
- Төслийн зорилго, зорилт, үе шат, үр дүн
- Төслийн танилцуулга



УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр авч үзэн 2023-2025 оныг “Монголд зочлох жил”-ээр зарлаад байна. Энэ хүрээнд “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо”-г байгуулж Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлэн ажиллаж байна.

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувийг дангаараа бүрдүүлдэг эл салбарын хувьд аялал жуулчлалыг зөвхөн “жуулчлах” гэдэг агуулгаас өөрчилж эдийн засгийн үр өгөөжийг бий болгох, улс орныхоо нэр хүндийг дэлхий дахинд өсгөх, тусгаар тогтнолоо бэхжүүлэх гэсэн өргөн агуулгаар харж, олон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Баянзүрх дүүргийн “Хөгжлийн зураглал 2030”-ийн хэрэгжилтийг хангах, эдийн засгийн өрсөлдөх чадвартай хүчирхэг дүүрэг болох алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх болон улсын ногоон хөгжлийн гол салбарын нэг болох аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тус төслийн хэрэгцээ шаардлага өндөр байна.

“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” (МАТ) төсөл нь БЗД-ийн нутаг дэвсгэр дээр эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох замаар байгаль орчноо хамгаалах, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, төр, хувийн хэвшлийн хамтын оролцоон дээр түшиглэн аялал жуулчлалын тогтвортой бизнесийг хөгжүүлж дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой төсөл юм.

Тус төсөл нь “Орон нутгийн эко аялал жуулчлалын кластер” байгуулах замаар төслийг хэрэгжүүлэхийг зорьж байгаагаараа онцлог юм.

Эко аялал жуулчлал нь манай улсад сайн хөгжөөгүй боловч эхлэл суурь нь (Хустай БЦГ-ийн аялал жуулчлалын жишээ) тавигдсан. Эко аялал жуулчлал нь байгаль, соёлыг дээдлэн, нутгийн иргэдийг татан оролцуулж, орон нутагт эдийн засгийн үр өгөөж авчирдаг, олон нийтийн аялал жуулчлалын сөрөг үр дагаврыг багасгадаг аялал жуулчлалын нэг хэлбэр гэж өргөнөөр хүлээн зөвшөөрдөг.

“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” (МАТ) төсөл нь “Орон нутгийн эко аялал жуулчлалын кластер” байна гэж үзэж, түүний хүрээнд төр, хувийн хэвшил, аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллага холбоод, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, зочид буудал, хүнс хоол, худалдаа үйлчилгээ эрхлэгчидтэй орон нутгийн иргэд малчид нэгдэн ажиллах боломжтой болж орон нутаг байгаль хамгаалал, нийгэм, эдийн засгийн хувьд хөгжих хөшүүрэг бий болно.

Жуулчдын дэлхий нийтийн чиг хандлага сүүлийн үед хөндөгдөөгүй унаган байгаль, нутгийн өв соёлоо хэвээр хадгалсан жинхэнэ бодит орчинг мэдрэх газрууд руу аялахыг хүсч байгаа нь бидний төслийн хувьд бодит боломж байж болох бөгөөд зах зээлийн эрэлтийн энэ чиг хандлагыг сайн мэдэрч, угаж бэлдэн дүүрэг болон орон нутгийн иргэдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхийг зорих нь зүйтэй юм.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого;
- Ногоон хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний үзэл



баримтлал

- Баянзүрх дүүргийн хөгжлийн зураглал 2030

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЕ ШАТ, ҮР ДҮН

Алсын хараа (20 жил)

Хүн, байгаль, соёлын эх өвөө хадгалан хөгжсөн “ДЭЭДСИЙН НУТАГ ДЭНДИЙ”

Эрхэм зорилго (10 жил)

Монгол ахуй соёл, түүх, унаган байгалиа олон улсад сурталчилна, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.

Үнэт зүйл (4Х)

- Хайрлах (Compassion): Унаган байгаль, монгол ахуй соёл, түүхэн уламжлалаа хайрлан хамгаалах
- Хамтрах (Community): Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, хөгжүүлэх
- Хамгаалах (Conservation): Экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах
- Холбох (Connection): Жуулчид, аялагчдыг тухайн газар нутгийн байгаль, түүх, хүн ард, ахуй соёлтой танилцах, холбогдоход туслах, дэмжих

Төслийн зорилго:

“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” (МАТ) төсөл нь БЗД-ийн нутаг дэвсгэр дээр эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох замаар байгаль орчноо хамгаалах, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, төр, хувийн хэвшлийн хамтын оролцоон дээр түшиглэн аялал жуулчлалын тогтвортой бизнесийг хөгжүүлж дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьж буй төсөл юм.

Төсөл нь дараах зорилгыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилго 1. Баянзүрх дүүрэгт “Монгол ахуй” аялал жуулчлалын кластерийг хөгжүүлнэ.

Зорилго 2. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үр дүнтэй менежментийг хэрэгжүүлнэ.

Зорилго 3. Хот төлөвлөлт, барилга, дэд бүтцийн ногоон стандарт нутагшсан загвар бүс болно.

Зорилго 4. Олон талт хамтын ажиллагааны сайн менежментийг хэрэгжүүлнэ.

Зорилго 5. Агаар, хөрс, усны бохирдлоос сэргийлж, экосистемийн үйлчилгээ, ашиг тусыг хүртэнэ.

Зорилго 6. Иргэдийн амарч зугаалах ая тухтай орчинг бүрдүүлнэ.

Төслийн зорилтууд:

Төсөл зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилго 1. Баянзүрх дүүрэгт “Монгол ахуй” аялал жуулчлалын кластерийг хөгжүүлэх хүрээнд:

1.1. Кластерийн орон зайн байршил, маршрутыг Нийслэлийн аялал жуулчлалын



бүстэй уялдуулан оновчтой тогтоож, тээврийн хэрэгсэл саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх

- 1.2. БЗД-ийн Гачууртын Их Дэндийн аманд түүх танин мэдэхүйн, соёлын, байгалийн, амралт чөлөөт цагийн, эрүүл мэнд сайн сайхан байдлын, тусгай сонирхлын төрөлд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
- 1.3. Нутгийн иргэдийг уламжлалт мал аж ахуйгаа аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлж орлогоо нэмэгдүүлэн амьдралын чанараа дээшлүүлэх боломжийг нээх
- 1.4. Дижитал шилжилтийг ашиглан хүртээмжтэй марктенг хийж, гадаад, дотоодын аялагч, жуулчдад хүрч үйлчлэх
- 1.5. Аяллын маршрутын дагуу түр буудаллах цэг, отгуудыг байгуулж аялагч, жуулчдын тав тухыг хангаж, үйлчилгээний нэр төрлийг олшруулах

Зорилго 2. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 2.1. Аялал жуулчлалын кластерийн дэд бүтцийн төлөвлөлтийг улс, нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан улсын төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- 2.2. Төр, хувийн хэвшил, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт харилцан ашигтай бизнесийн орчныг бүрдүүлж хөгжлийн хөрөнгө оруулалтыг татаж, нутагшуулах
- 2.3. Эвент менежментийг хөгжүүлэн, аялал жуулчлал, соёл урлаг, спортын мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалт татах
- 2.4. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын шимтгэл зэрэг хэрэглэгчдээс орох орлогыг дэмжих
- 2.5. Аялал жуулчлалаар дамжуулан дүүргийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх

Зорилго 3. Хот төлөвлөлт, барилга, дэд бүтцийн ногоон стандарт нутагшсан загвар бүс болох хүрээнд:

- 3.1. Олон Улсын аялал жуулчлалын үйлчилгээний болон ногоон барилгын стандартыг нутагшуулсан нийслэлийн аялал жуулчлалын загвар бүс болох
- 3.2. Дэд бүтэц, барилга байгууламжийг экологид ээлтэй, барилгын ногоон стандартын дагуу төлөвлөж, байгаль орчны нөөц даацад дарамтгүй байхаар барьж байгуулах
- 3.3. Үндэсний уламжлалт сууцны онцлогийг орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулан экологид ээлтэй тогтвортой орон сууц барих
- 3.4. Гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж судалгаа, бүтээлийг марктенгийн бодлогод ашиглах

Зорилго 4. Олон талт хамтын ажиллагааны сайн менежментийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 4.1. Олон улс, Монгол улс, нийслэлийн байгаль орчин, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөөх түншлэлийн хүрээг өргөжүүлэх



- 4.2. Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, байгаль орчныг хамгаалахад бүх талын оролцоог нэмэгдүүлж, орон нутаг, иргэд, аялагч жуулчдад ээлтэй орчинг хамтын хүчээр бүрдүүлэх
- 4.3. Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалах нөхөрлөл байгуулахыг дэмжих, чадавхыг бэхжүүлэх
- 4.4. Нутгийн иргэдийн дунд тогтвортой аялал жуулчлалын боловсрол олгох ажлыг зохион байгуулж ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх
- 4.5. ЕБС, цэцэрлэгтэй хамтран монгол ахуй, соёлд суралцах боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх

Зорилго 5. Агаар, хөрс, усны бохирдлоос сэргийлж, экосистемийн үйлчилгээ, ашиг тусыг хүртэх хүрээнд:

- 5.1. Гачууртын Дэндийн амыг “Монгол ахуй” аялал жуулчлалын кластерийн тусгай бүс нутаг болгон хөгжүүлэх (Орон нутгийн тусгай хамгаалалтад авах)
- 5.2. Хүний хөлд дарагдаагүй байгалийн гоо үзэсгэлэнгээ хэвээр хадгалсан, жуулчдын зорин очих үнэ цэнтэй газар байж, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх
- 5.3. Баялгийг зөв зохистой, хэмнэлттэй хэрэглэх замаар байгалийн нөөц баялгийг нэмэгдүүлэх, үнэ цэнийг нэмэх (рашаан ус, ойн баялаг гм)
- 5.4. Дэндийн амны үзэсгэлэнт байгалийг аюул гамшиг (гал түймэр, ойн хортон шавж гм)-аас хамгаалан, экосистемийн үйлчилгээний нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

Зорилго 6. Иргэдийн амарч зугаалах ая тухтай орчинг бүрдүүлэх хүрээнд:

- 6.1. Нүүдлийн уламжлалт ахуй соёл, экосистемийн тэнцвэрт байдлаа хадгалсан аялал жуулчлалын бүс нутаг байж болохыг харуулсан загвар төсөл болох
- 6.2. УБ хотын дотор, хамгийн ойр зайнд экосистемийн үйлчлэлийн үр шимийг хотын иргэдэд хүртээх
- 6.3. Бух насны иргэдийг жилийн дөрвөн улиралд, эрүүл байгаль орчинд амарч зугаалах боломжийг нээж, амралт, аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх
- 6.4. Аялал жуулчлалын аюулгүй байдлыг хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх
- 6.5. Хүүхэд, залуусын соёлтой амрах, байгаль орчинтой зөв харьцах, хайрлан хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Төслийн үе шат (зураг 1)

“Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төслийг дараах 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд:

I ҮЕ ШАТ: 2024-2027 он. Кластерийн бүтээн байгуулалтын үе. (кластерийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж дуусгах үе)

II ҮЕ ШАТ: 2027-2030 он. Кластерийн тогтвортой хөгжлийн үе. (аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ тогтворжиж, өрсөлдөх чадвартай эко аялал жуулчлалын кластер болж хөгжих үе)

Төслийн үр дүн (зураг 1)



Нийгэм, эдийн засгийн хүрээнд:

- Тогтвортой аялал жуулчлал хөгжиж ногоон ажлын байр нэмэгдэх;
- Орон нутгийн иргэдийн орлого нэмэгдэж, амьжиргаа дээшлэх;
- Оролцогч талуудын үр дүнтэй, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа;
- Аялал жуулчлалын экологид ээлтэй дэд бүтэц, барилга байгууламж баригдах гм

Байгаль орчны хүрээнд:


- Байгалийн нөөцийг үнэлж үр дүнтэй, хэмнэлттэй ашиглах, экологийн эрсдэлийг бууруулах
- Ногоон стандарт, цэвэр технологийг нэвтрүүлэх
- Тухайн газар нутгийн өнгө үзэмж, ландшафтыг сайжруулах гм

Соёлын хүрээнд:

- Нутгийн иргэдийн уламжлалт ахуй соёл үнэт зүйлийг хүндэтгэх, хэвээр хадгалах
- Түүх археологийн дурсгалт зүйлсийг хамгаалах, таниулах
- Аялал жуулчлалыг, соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх
- Монголын үндэсний наадам, спортын төрлүүдийг хөгжүүлэх гм



Зураг 1. Төслийн хэрэгжих үе шат, үр дүн





Өв соёлын “МОНГОЛ АХУЙ” цогцолбор (төслийн танилцуулга)

МЭДЭЭЛИЙН НЭР	ТАЙЛБАР
Цогцолборын зорилго	Монголын уламжлалт ахуй, биет бус өвийг соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй хослуулан, нутгийн иргэдэд түшиглэсэн хэлбэрээр аялагч, жуулчдад сурталчлах, танин мэдүүлэх, хүүхэд залууст өвлүүлэн уламжлуулах зорилготой цогцолбор
Цогцолборын бүрэлдэхүүн, барилга байгууламж	
А. Монгол ахуй цогцолбор	
1.Хүндэтгэлийн өргөө: 1 гэр (10 ханатай, 50-60 хүний багтаамжтай)	Цогцолборын төв хэсэгт монгол ахуй болон соёлын биет бус өвийн талаарх мэдээлэл бүхий үзмэр дэглэгдсэн, зочид хүлээн авах боломжтой хүндэтгэлийн өргөө байна. Гэр нь уламжлалт хийцтэй эсвэл модон каркасан хийцтэй цомцог гэр байж болно. Хүндэтгэлийн өргөөний доор цоклийн давхартай барилга хэлбэрийн суурь байх ба дотор нь гал тогоо, техникийн өрөө, агуулах, ариун цэврийн өрөөнүүд байна. Жишээ нь суурийн гадна дизайн нь гэр тэрэг шиг байж болно (зураг төслийн архитектурын шийдлээр тодорхой болно).
2.Соёлын биет бус өвийн гэрүүд: 14 гэр Соёлын биет бус өвийн 7 ай савын төлөөлөл хоёр хоёроороо хос гэрүүд (1 гэр нь 8 ханатай, 30-40 хүний багтаамжтай)	Соёлын биет бус өвийн гэрүүд нь хүндэтгэлийн өргөөг тойрон нарны цацраг хэлбэртэй байрласан, ханаараа нийлсэн хос гэрүүд байна. Нэг гэрт нь соёлын биет бус өвийн нэг ай савын жишээ нь ардын язгуур урлагийн талаарх цогц мэдээлэл, үзмэр байрлаж нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, нөгөө гэрт нь тухайн соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах шавь сургалт явагдах ба мөн сонирхсон аялагч, жуулчид биечлэн оролцох боломжтой. Гэрүүд нь уламжлалт хийцтэй монгол гэрүүд байна. Соёлын биет бус өвийн 7 ай сав: <ul style="list-style-type: none"> • Эх хэл, аман уламжлал • Ардын язгуур урлаг • Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа • Байгалийн болон сав шим, ертөнцийн тухай мэдлэг, зан үйл • Уламжлалт арга ухаан • Мал маллах арга ухаан • Уламжлалт гар урлал
Тохижилт	<ul style="list-style-type: none"> • Автомашины зогсоол • Явган хуний зам, хогийн сав (орон нутгийн байгалийн материал ашигласан) • Нийтийн ариун цэврийн байгууламж



	<ul style="list-style-type: none"> Гэрэлтүүлэг (цөөн, сарнисан гэрэлтэй) Амрах зориулалттай ширээ, сандал гм
Дэд бүтэц	
Зам, тээвэр	Байгалийн шороон зам
Цахилгаан	Нэгдсэн болон бие даасан эх үүсвэртэй байж болно
Дулаан	Цахилгаанаар халаах
Ус хангамж	Бие даасан эх үүсвэртэй
Ариутгах татуурга	Бие даасан эх үүсвэртэй
Мэдээлэл, холбоо	Үүрэн холбоо, интернэт
Б. Айраг, адууны соёлын отог	
Гүүтэй айл дээр түшиглэн байгуулна Хот айл: Эзэн айлын гэр, айраг, адууны тоноглол хэрэгслийн гэр, зочид байрлах 1-2 гэр, гүүн зэл, морины уяатай байх	ЮНЕСКО-д бүртгэлтэй монголын хөхүүрийн айрагны өв соёлыг нутаг орондоо хадгалах, хойч үедээ өвлүүлэх, аялагч жуулчдад таниулах, айрагны өв соёлоо хадгалагч гүү барьдаг айл, гүү саадаг эзэгтэй нарыг дэмжих, хүүхэд залуусыг гүүний айргаа мэддэг, уудаг болгох, нийслэлийн иргэдэд уламжлалт эрүүл хүнсээр үйлчилж, дархлаагаа сайжруулахад нь туслах; Унага татах, айраг бүлэх зэрэг ажилд жуулчдыг биечлэн оролцуулах; Айрагны соёлын нэг хэсэг хуруу гаргах, дэмбээдэх зэрэг наадгайд зочдыг урьж оролцуулах, зааж өгч хамт тоглож наадах зэрэг олон сонирхолтой хөтөлбөрийг санал болгоно.
В. Нүүдэлчин отог	
Сарлаг, үхэртэй айл дээр түшиглэн байгуулна. Тэмээтэй бол нэн сайн Хот айл: Эзэн айлын гэр, зочид байрлах 1-2 гэр, банаг, үхэр тэрэг, тоног хэрэгсэл, уналгын морь, ачлагын хайнаг, ачлагын тэмээтэй байх	Монголчуудын усны тунгалаг, өвсний соргогийг хайн нүүдэллэх уламжлалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон үзүүлэх, монгол гэр, тавилга нүүдлийн ахуйтайгаа яаж хослон хөгжсөнийг харуулах, ширхэг хадаас ч ороогүй хэр нь олон жилийн эдэлгээ даадаг үхэр тэрэгний дугуй зэрэг нүүдэлчдийн технологийг жуулчдад таниулах; Монголчуудын биет өв гэр нь ур хийц, хэрэглээний хялбар байдал, сонин содон дизайнаараа дэлхийд хэдийнээ танигдсан иймээс нүүдэллэхээр гэрээ ачаалах, нүүдлээс бууж гэрээ барих, гэрт хонох зэргээр жуулчдыг биечлэн оролцуулах олон сонирхолтой хөтөлбөрийг санал болгоно.
Г. Хоньчин отог	
Хонь, ямаатай хот айл дээр түшиглэн байгуулна. Хот айл: Эзэн айлын гэр, цагаан идээний гэр, зочид байрлах 1-2 гэр, банагтай байх	Хонь хариулах, хонины ноосоор хийсэн эсгийгээр гар урлалын зүйл хийх, эсгий эдлэлийн худалдаа зохион байгуулах ноос савах, хурганы арьс элдэх, хонины үүлдэр



		танилцуулах, хонины сүүгээр цагаан идээ хийж амтлуулах, жуулчдаар өөрсдөөр нь эсгий болон ноосоор бэлэг дурсгалын зүйл хийлгэж өөрт нь дурсгах зэрэг сонирхолтой хөтөлбөрийг санал болгоно. Мөн хоньчин отог дээр “цагаан ямааны сүү” уух ардын уламжлалт эмчилгээний зан үйлтэй холбоотой зочин гэр байна.
Д. Цагаан идээний отог		
Үхэртэй айл дээр түшиглэн байгуулна. Хот айл: Эзэн айлын гэр, цагаан идээний гэр, зочид байрлах 1-2 гэртэй байх		Монголчуудын идээ зоогт цагаан идээ нэн тэргүүнд ордог. Үнээний сүүгээр хийсэн бүтээгдэхүүн нь монголчуудын цагаан идээний хэрэглээний дийлэнх хэсгийг эзэлдэг бөгөөд ээдэм, өрөм, ааруул, бяслаг, цөцгийн тос, тараг зэрэг нь кальциар баялаг учир хүүхдийн өсөлт хөгжил, шүдний бат бэх чанарыг сайжруулахад маш тустай тул зун цагт хүүхдэд цагаан идээ хэрэглүүлэхийг монгол хүн бүр хүсдэг. Мөн экологийн цэвэр бүтээгдэхүүн болох цагаан идээг гадаадын жуулчид ч их сонирхдог тул цагаан идээ боловсруулахыг жинхэнэ бодит байдлаар харуулах, биечлэн оролцуулах, хамтран хийх хөтөлбөрийг санал болгоно.
Байршил, бүсчлэл		
Байршил		Гачууртын Их Дэндийн амны Шилжир уулын бэл болон зүүн талын бага амууд
Бүсчлэлийн нэр, талбайн хэмжээ		
1. Өргөө цогцолбор	5.0 га	Арцатын зоо, Шилжир уулын баруун бэлд, Дэндийн голын эхэнд
2. Айраг адууны соёлын отог	1.0 га	Номт уулын баруун амны эхэнд Дэндийн голын зүүн талд
3. Нүүдэлчин отог	1.0 га	Дүнхэн уулын баруун амны эхэнд Дэндийн голын зүүн талд
4. Хоньчин отог	1.0 га	
5. Цагаан идээний отог	1.0 га	Богинын амны эхэнд Дэндийн голын зүүн талд
Одоогийн газар ашиглалт		Хоосон газар
Төсөл хэрэгжих хугацаа		
ТЭЗҮ, зураг төсөл		2024 он
Бүтээн байгуулалт		2024-2025 он
Бүрэн хүчин чадлаараа ажиллах		2025 оноос
Төслийн бүтээгдэхүүн үйлчилгээ		
Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ		“Баянзүрх Соёлын өв” эвент: Жилд нэг удаа монголын соёлын 7 ай савын 1-2 өвийг жуулчдад үзүүлж, дараагийн жил өөр өвийг үзүүлэх зэргээр дахин ирэх сонирхлыг төрүүлж, жуулчдыг татна. Хуримын ёслол: Монголын олон ястны уламжлалт ёс заншлаар гэрлэх



	<p>сонирхолтой хосуудад зориулсан тусгай хөтөлбөртэй байна. Сүүлийн үед гаднын иргэд ч монгол оронд ирж хуримаа хийх зан үйл ажиглагдаж байна.</p> <p>Жуулчдад зориулсан бэсрэг наадам, Жороо морины уралдаан: Үндэсний эрийн гурван наадам (өнөө цагт шагайн харваа нэмэгдсэн) -ыг бэсрэг хэлбэрээр хийхэд Дэндийн ам маш тохиромжтой нөхцөлтэй бөгөөд гадаад дотоодын аялагч, жуулчид монгол үндэсний наадмыг нэг дороос үзэж сонирхох боломжийг олгоно.</p> <p>Айрагны баяр: Сайхан айраг, сайхан хөхүүр шалгаруулах, хэн сайн дэмбээдэх, хуруудах вэ зэрэг тэмцээн зохион байгуулж жуулчдад монголын айраг, адууны соёлыг таниулж биечлэн оролцуулна.</p> <p>Үндэсний уламжлалт цагаан идээ, хоол ундааны фестиваль: Зуны дэлгэр цагт орон нутгийн иргэдийн боловсруулсан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргаж аялагч жуулчдад монгол бэлчээрийн малын ашиг шим, эко хүнсний бүтээгдэхүүний ач холбогдлыг сурталчлан, худалдан борлуулна.</p>
Архитектур, орон зайн төлөвлөлтийн онцлог байдал	
Тогтвортой байдал	Гэр цогцолбор болон туслах барилга, байгууламж нь байгалийн болон монгол ахуй амьдрал, соёлын өвийн нөөцөд сөргөөр нөлөөлөхгүй. Орон нутгийн иргэд үндсэн мал аж ахуйгаасаа гадна цогцолборын үйл ажиллагаанд оролцон нэмэлт орлого олох боломж бий болно. Тухайлбал нутгийн эмэгтэйчүүд цогцолборын соёлын өвийн сургалтуудад хамрагдаж мэдлэг, чадвараа сайжруулах түүнийгээ ашиглан орлого олох боломж улам илүү байна.
Хүртээмжтэй байдал	Улаанбаатар хотын төвөөс 30 км-ийн тойрогт, хотын эрчимтэй таталцлын бүсэд байрладаг тул дүүргийн болон хотын иргэд, аялагч жуулчид ирж амрахад хамгийн тохиромжтой аялал жуулчлалын бүс болно.
Тав тухтай байдал	Цогцолбор нь дулааны улиралд хамгийн сайн зохицох бөгөөд өвлийн болон сэрүүн улиралд халаалтыг орчин үеийн экологид ээлтэй технологиор шийднэ.
Өвөрмөц байдал	Монголын уламжлалт архитектурын өв, сууц болох гэр түүнийг багатаасан тойрог хэлбэрийн “Хүрээ төлөвлөлт” нь манай орны хот төлөвлөлтийн үндэс болдог



Төсөл

	өвөрмөц онцлогтой.
Зохицол	Цогцолборын дүр төрх тухайн газрын байгаль орчин, монгол ахуйтай бүрэн зохицохоос гадна орчны тав тухтай байдлыг хөндөхгүй.
Ижил төстэй байдал	Их Дэндийн амны орчим өөр ийм цогцолбор байхгүй.
Өрсөлдөх чадвар	Тухайн аялал жуулчлалын бүс буюу Дэндийн аманд дахин ийм төрлийн цогцолборыг төлөвлөхгүй.
Хэмжээ	Тухайн төслийг хэрэгжүүлэхэд төлөвлөж буй газрын хэмжээ нь хангалттай.
Чиг үүрэг	Цогцолборын, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндсэн үүрэг нь тухайн аялал жуулчлалын бүсэд зайлшгүй шаардлагатай чиг үүрэг юм.
Хөрөнгө оруулалт	
Нийт өртөг	Нарийвчилсан зураг төслийн шатанд тодорхой болно
Санхүүжилтийн хэлбэр	Хувийн хэвшлийн болон бусад хөрөнгө оруулалт



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН

"МОНГОЛ АХУЙ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН КЛАСТЕР"

Төсөл